



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/072/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 214
танай _____-ны № _____-т

МӨНХХАЙРХАН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
У.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 12,829 хүүхэд өдөр ажиллаж улсын төсвөөс 651,924.6 мянга, орон нутгийн төсвөөс 67,135.0 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 2 дугаар түвшинд 1 багш, 3 дугаар түвшинд 4 багш үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн үнэлгээгээр 95.3 хувиар буюу 3 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>112,621,222.97</u>	<u>77,876,152.97</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	51,032,134.97	25,112,234.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,032,134.97	25,112,234.97
3121	Төгрөг	51,032,134.97	25,112,234.97
31211	Төрийн сангийн харилцах	51,032,134.97	25,112,234.97
35	БАРАА МАТЕРИАЛ	61,589,088	52,763,918
351	Түүхий эд материал	79,300	79,300
35130	Эм боох материал	79,300	79,300
354	Хангамжийн материал	61,509,788	52,684,618
35410	Бичиг хэргийн материал	633,800	1,002,800
35420	Аж ахуйн материал	2,340,602	3,397,302
35460	Хүнсний материал	17,958,960	6,113,010
35470	Бусад хангамжийн материал	40,576,426	42,171,506
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>399,997,475.12</u>	<u>368,202,840.87</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	399,997,475.12	368,202,840.87
392	Биет хөрөнгө	392,217,475.12	360,422,840.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	404,031,640	404,031,640
39202	Хуримтлагдсан элэгдэл	(91,603,367.02)	(111,144,779.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,267,682	36,516,324
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,803,400.16)	(25,972,982.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,611,500	45,750,798
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,360,947.87)	(13,977,027.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,159,875	32,908,875
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,242,082.83)	(11,846,582.79)
39217	Ном	4,156,576	4,156,576
393	Биет бус хөрөнгө	7,780,000	7,780,000
39301	Програм хангамж	557,000	557,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(557,000)	(557,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,780,000	7,780,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>512,618,698.09</u>	<u>446,078,993.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,785,263.51</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,785,263.51
413	Өглөг	-	3,785,263.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,457,751.51
4136	Бусад өглөг	-	1,327,512
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,327,512
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>512,618,698.09</u>	<u>442,293,730.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	512,618,698.09	442,293,730.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	117,259,834	117,259,834
51101	Өмч: - төрийн	117,259,834	117,259,834
512	Хуримтлагдсан үр дүн	277,669,860.82	207,344,893.06
51210	Өмнөх үеийн үр дүн	277,669,860.82	281,825,894.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	(74,481,001.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,689,003.27	117,689,003.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>512,618,698.09</u>	<u>446,078,993.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	696,655,376	722,235,154
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,032,876	3,175,454
120	Нийтлэг татварын бус орлого	25,032,876	3,175,454
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,032,876	3,175,454
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,032,876	3,175,454
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	671,622,500	719,059,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	599,084,600	651,924,600
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	599,084,600	651,924,600
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,817,200	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,817,200	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,720,700	67,135,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,720,700	67,135,100
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	671,866,419.83	796,716,155.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,866,419.83	796,716,155.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,545,214.71	795,858,358.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,429,014.94	563,763,031.57
210101	Үндсэн цалин	355,569,913.58	334,184,961.52
210102	Нэмэгдэл	94,289,439.62	191,233,580.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,680,000
210104	Урамшуулал	6,569,661.74	24,664,490
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,480,427.77	70,732,153.92
210201	Тэтгэврийн даатгал	35,957,897.57	47,919,857.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,760,034.30	5,553,871.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,507,558.15	3,206,228.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,877,788.15	2,776,935.67
210205	Эрүүл мэндийн даатгал	8,377,149.60	11,275,260.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,159,494.88	64,110,902.70
210301	Гэрэл, цахилгаан	4,196,968.48	5,604,568.30
210302	Түлш, халаалт	58,162,526.40	57,706,334.40
210303	Цэвэр, бохир ус	800,000	800,000
2105	Нормативт зардал	38,602,013	39,605,750
210502	Хоол, хүнс	38,602,013	39,605,750
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,100,100
210604	Урсгал засвар	-	2,100,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,530,650	1,162,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,817,200	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,713,450	1,162,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,343,614.12	54,383,920.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,026,000	9,975,032
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	173,850	4,539,700
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,143,764.12	39,869,188.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,205.12	857,797.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	321,205.12	857,797.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,205.12	857,797.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,788,956.17	(74,481,001.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	24,788,956.17	(74,481,001.74)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	671,622,500	719,059,700
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	671,622,500	719,059,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	599,084,600	651,924,600
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	599,084,600	651,924,600
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,817,200	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,817,200	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,720,700	67,135,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,720,700	67,135,100
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	636,967,251.69	744,979,600
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,967,251.69	744,979,600
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,646,046.57	744,121,802.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,322,267.69	555,360,200
210101	Үндсэн цалин	278,490,459.64	345,248,508.22
210102	Нэмэгдэл	157,636,093.31	163,915,899.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,420,661.90
210104	Урамшуулал	19,195,714.74	32,775,130
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,179,234	65,521,200
210201	Тэтгэврийн даатгал	36,152,822	44,558,600
210202	Тэтгэмжийн даатгал	4,259,945	5,242,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,129,972	2,622,200
210204	Ажилгүйдлийн даатгал	2,129,972	2,622,200
210205	Эрүүл мэндийн даатгал	8,506,523	10,475,800
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,159,494.88	64,110,902.70
210301	Гэрэл, цахилгаан	4,653,160.48	5,604,568.30
210302	Түлш, халаалт	57,706,334.40	57,706,334.40
210303	Цэвэр, бохир ус	800,000	800,000
2105	Нормативт зардал	35,338,950	27,759,800
210502	Хоол, хүнс	35,338,950	27,759,800
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,240,000	2,166,400
210604	Урсгал засвар	2,240,000	2,166,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,541,400	2,714,100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,817,200	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,724,200	2,714,100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,864,700	26,489,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,458,400	21,845,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,406,300	4,644,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,205.12	857,797.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	321,205.12	857,797.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,205.12	857,797.30

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,655,248.31	(25,919,900)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,655,248.31	(25,919,900)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		51,032,134.97
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	51,032,134.97	25,112,234.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	277,669,860.82	512,618,698.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	277,669,860.82	512,618,698.09
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(207,932,531.74)	(207,932,531.74)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	69,737,329.08	304,686,166.35
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	69,737,329.08	304,686,166.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,156,033.98	4,156,033.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	73,893,363.06	308,842,200.33
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(74,481,001.74)	(74,481,001.74)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003.27	(587,638.68)	234,361,198.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	771,664,600	744,121,802.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,664,600	744,121,802.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,514,300	744,121,802.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,841,500	555,360,200
210101	Үндсэн цалин	332,468,700	345,248,508.22
210102	Нэмэгдэл	208,777,200	163,915,899.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,595,600	13,420,661.90
210104	Урамшуулал	-	32,775,130
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,183,400	65,521,200
210201	Тэтгэврийн даатгал	47,608,200	44,558,600
210202	Тэтгэмжийн даатгал	5,643,800	5,242,400

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,821,900	2,622,200
210204	Ажилгүйдлийн даатгал	2,821,900	2,622,200
210205	Эрүүл мэндийн даатгал	11,287,600	10,475,800
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,968,700	64,110,902.70
210301	Гэрэл, цахилгаан	6,448,700	5,604,568.30
210302	Түлш, халаалт	57,720,000	57,706,334.40
210303	Цэвэр, бохир ус	800,000	800,000
2105	Нормативт зардал	40,137,600	27,759,800
210502	Хоол, хүнс	40,137,600	27,759,800
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,166,400	2,166,400
210604	Урсгал засвар	2,166,400	2,166,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,714,100	2,714,100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,714,100	2,714,100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,502,600	26,489,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,858,600	21,845,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,644,000	4,644,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,150,300	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,150,300	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,150,300	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	771,664,600	718,201,902.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	704,529,500	651,924,600
131001	Улсын төсвөөс санхүүжих	704,529,500	651,924,600
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,135,100	66,277,302.70
132001	Орон нутгийн төсвөөс	67,135,100	66,277,302.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	51,032,134.97
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	25,112,234.97
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	18
620001	Удирдах ажилтан	1	3
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	-	1
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1	1
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	18
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	3	3

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 27,688.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 21,433.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан, худалдан авсан 1,601.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй,
- өмнөх онд үүссэн 4,156.0 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй, тайлант онд залруулаагүй,
- Өглөгийг 3,432.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн үлдэгдэл 857.8 мянган төгрөгийг тохируулга бичилт хийгээгүй,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал, тайлан үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн өмнөх үеийн үр дүн данс руу залруулах бичилтийг нийт 11,386.5 мянган төгрөгөөр зөрүүтэй,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 6,282.0 мянган төгрөгийн 6 зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,254.8 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 2,002.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,252.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага нь эд хариуцагч нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/14 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр 884,000 (найман зуун наян дөрвөн мянган) төгрөгийн балансын урамшуулал гэсэн утгаар давхардуулан олгож буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй нь *Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнеа хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.2 Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 12,829 хүүхэд өдөр ажиллаж хүүхдийн хоногт зарцуулах нормоор тооцоход 38,487.0 мянган төгрөгийг зарцуулахаар байхад гүйцэтгэлээр 39,605.7 мянган төгрөгийг зарцуулж нормоос 1,118.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2024 оны 237 дугаар “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 1.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай,” гэж заасантай нийцээгүй, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдээдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 3910 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж, ирцийг бүртгэж хэвших,

3.2.2 Хоол хүнсний материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд даршилсан огуурцы, алаг салат, хиам, лечо зэрэг 3,923.5 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг хоол хүнсэнд хэрэглэсэн, шатахууны зарцуулалт хангалтгүй, хоолны зардлаас эцэг эхийн нөхөрсөг уулзалт, хоолны үзэсгэлэнд нийт 3,923.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/166, А/559, 222 дугаар “норматив батлах тухай” тушаалаар 1."Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт"-ыг нэгдүгээр, "Цэцэрлэгийн насны хүүхдийн

хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”, нийцээгүй гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоол хүнсэнд шаардлага хангасан бүтээгдэхүүн олгох,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг	5	21,433.9	3	6,615.3	2	14,818.6	5	21,433.9	-	-	-	-
Дүн	5	21,433.9	3	6,615.3	2	14,818.6	5	21,433.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг	4	6,264.8	2	2,002.7			2	4,262.1	-	-	-	-
Дүн	4	6,264.8	2	2,002.7	-	-	2	4,262.1	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-